

05.4. Кино театр, караоке, эвент танхимын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

Үүсэж болзошгүй эрсдэлийн тодорхойлолт: Үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмж алдагдах

Үнэлгээ хийх объект: Кино театр, караоке, эвент танхим

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Барилга, байгууламж		
1.1	Барилга, байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдаагүй, зориулалтын бус, стандартын шаардлага хангаагүй, ашиглалтын шаардлага хангахгүй, эсхүл урсгал засвар хийх тухай барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан	10
1.2	Барилга, байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдсан боловч зориулалтын бус, урсгал засвар хийх шаардлагатай	5
1.3	Барилга, байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын, стандартын шаардлага хангасан	1
Хоёр. Техник, тоног төхөөрөмж		
2.1	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь мэргэжлийн бус, хүрэлцээгүй, техник хэрэгсэл, зэмсгийг зориулалтын бусаар ашигладаг	10
2.2	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь мэргэжлийн, хүртээмжтэй боловч шинэчлэх шаардлагатай	5
2.3	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь мэргэжлийн өндөр түвшний бөгөөд хүртээмжтэй, зориулалтаар нь бүрэн ашигладаг	1
Гурав. Мэргэжлийн боловсон хүчин		
3.1	60 хүртэл хувь нь мэргэжлийн ажилтантай	10
3.2	61-99 хүртэлх хувь нь мэргэжлийн ажилтантай	5
3.2	Мэргэжлийн ажилтнаар бүрэн хангагдсан	1
Дөрөв. Бүтээлч үйлдвэрлэл		
4.1	Хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулдаггүй	10
4.2	Хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг дэмжсэн арга хэмжээг жилд 4 хүртэл зохион байгуулдаг	5
4.3	Хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг дэмжсэн арга хэмжээг жилд 4-өөс дээш удаа зохион байгуулдаг	1
Тав. Тэгш хүртээмж		
5.1	Хүүхэд залуус болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан соёл, урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаггүй	10

5.2	Хүүхэд, залуус болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан соёл, урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтмолжоогүй	5
5.3	Хүүхэд, залуус болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан соёл, урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтмолжсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж барилга, байгууламжийн дэд бүтцийг хөгжүүлсэн	1
Зургаа. Үйлчилгээний соёл		
6.1	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд 2 буюу түүнээс дээш гомдол гарч байсан	10
6.2	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд гомдол гарч байсан	5
6.3	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар гомдол гарч байгаагүй, үйлчилгээний ажилтнууд соёл, ёс зүйн сургалтад хамрагдаж мэргэшсэн	1
Долоо. Зохиогчийн эрх, зохиолын агуулга		
7.1	Оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчсөн, дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхэлсэн, уран бүтээлчийн анхдагч санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулсан, нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 30 хувиас доош, эдгээр асуудлаар жилд 2-оос дээш удаа гомдол гарч байсан	10
7.2	Дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлээгүй боловч оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчсөн, уран бүтээлчийн анхдагч санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулсан, нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 30-40 хүртэл хувь, эдгээр асуудлаар жилд 2 хүртэл гомдол гарч байсан	5
7.3	Оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй, дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа эрхлээгүй, уран бүтээлчийн анхдагч санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулаагүй, нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас дээш байдаг ба эдгээр асуудлаар гомдол гарч байгаагүй	1
Найм. Дотоодын хяналтын тогтолцоо		
8.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтангүй	10
8.2	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай боловч үйл ажиллагаа хэвшээгүй	5
8.3	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай, үйл ажиллагаа хэвшсэн	1
Ес. Өмнөх хяналт шалгалтын түүх		
9.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
9.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
9.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

45-90 оноо авсан бол их эрсдэлтэй

27-44 оноо авсан бол дунд эрсдэлтэй

26 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй